



147

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 09 сарын 09 өдөр


Дугаар 293

Улаанбаатар хот

Стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө
батлуулах тухай

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги”-ийг нэгдүгээр, “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны 2009-2013 оны төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах стратегийн хэрэгжилтийг зохицуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр), Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газар (С.Энхболд) -т даалгасугай.
3. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл), аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
4. Эрүүл мэндийн байгууллага бүр дээр стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.



С.ЛАМБАА

8 0934

Эрүүл мэндийн сайдын 2009 оны
293 дугаар сарын 09-ний өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн (ХХМ) асуудал нь эрүүл мэндийн тогтолцооны нэг чухал хэсэг юм. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас 2005 онд гаргасан Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн талаарх бодлогын баримт бичиг, мөн аюултай хаягдлын хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, дахин боловсруулалт, эцсийн устгалд хатуу хяналт тавихад чиглэгдсэн Базелийн конвенци зэрэгт эрүүл мэндийн байгууллагаас гарч буй хог хаягдлыг байгаль орчин болон хүний эрүүл мэндэд халгүй технологиор устгах чиглэл баримталж байна.

Монгол улсын Эрүүл мэндийн салбарт ХХМ-ийн асуудалтай холбоотой шийдвэрлэвэл зохих олон тулгамдсан асуудал байна. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн хууль эрх зүйн зохицтой орчин бүрдүүлэх, салбарын бүх түвшинд ХХМ-ийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, халдвартгүйжүүлэх, устган зайлзулахад шаардагдах дэд бүтцийг боловсронгуй болгох шаардлага байна.

1.1 Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн хууль, эрх зүйн зохицуулалт

Монгол улсын Засгийн Газрын 2002 оны 135 дугаар тогтоолоор “Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журам”, Эрүүл мэндийн болон Байгаль орчны сайдын 2002 оны 249/201 тоот хамтарсан тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх болон устгах журам” батлагдсан нь эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Гэвч эмнэлгийн болон халдвартай хог хаягдлын менежментийг шийдвэрлэхэд зөрчилтэй асуудлууд гарсаар байна. Одоогийн зохицуулалт нь түр зуурын шинжтэй, эмнэлгийн хог хаягдлыг халдвартгүйжүүлэх олон хувилбарыг санал болгосон боловч устгах/шатаах байгууламжид тавих шаардлагыг нарийвчлан заагаагүй зэрэг сул талтай байгаа юм. Иймээс эрүүл мэндийн байгууллагын

ХХМ-ийн одоогийн зохицуулалтыг эргэн нягталж, үндэсний хэмжээний ХХМ-ийн төлөвлөгөө боловсруулах шаардлага урган гарч байна.

- Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулах талаар Монгол улсын Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөний (ЭМСМТ) стратегийн үйл ажиллагаанд тусгаж, ХХМ-д хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлагатай тэргүүлэх чиглэл бөгөөд үүнийг шийдвэрлэхэд улсын төсөвт тусгах болон олон улсын байгууллагын дэмжлэг чухал болохыг заажээ.

Монгол улс Киотогийн протокол, Базелийн конвенц, Удаан задардаг органик бохирдуулагчийн талаарх Стокгольмын конвенц зэрэг олон улсын томоохон конвенцид нэгдэн орсон тул ХХМ-д хүлэмжийн хий ялгаруулалтыг хязгаарласан, хүний эрүүл мэнд ба орчныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг дэмжин ажиллах нь зүйтэй юм.

1.2 Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулах хэрэгцээ, шаардлага

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэж буй хурц ирмэгтэй, халдвартай болон химиин хог хаягдлын цуглуулалт (зориулалтын бус гялгар уут, цаасан уут, картонон хайрцааг г.м.) шаардлага хангахгүй байгаа нь ажлын байрны болон орчны эрүүл мэндийн эрсдэлд хүргэж байна. Манай улс дэлхий дээр гепатит В, С вирусын халдвар хамгийн их тархсан улсын тоонд ордог тул бохир зүү, тариураар өвчин тархах бодит аюул нүүрлэсээр байгааг анхаарах нь чухал байна.

Манай улсын бараг бүх (90.9%) эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн тусгай хог хаягдлыг шатаан устгадаг ба шатаах зуух нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, агаар шүүх төхөөрөмжгүй байгаа нь орчныг бохирдуулах нэг эх үүсвэр болж байна.

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг халдвартгүйжүүлэх хамгийн зохимжтой, байгаль орчинд ээлтэй арга нь шатаах бус технологи бөгөөд бичил долгион, өндөр дараалтат уураар (автоклав) халдвартгүйжүүлэх зэрэг аргыг өнөөгийн практикт нэвтрүүлэх нь чухал юм. Түүнчлэн хог хаягдлыг ангилах, зөвшөөрөгдсөн устгалын талбайд тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ хийх, үлдэгдэл хогийг устгах зэрэг асуудлыг мөн шийдвэрлэх шаардлагатай байна.

Иймээс өөрийн орны нөхцөл байдал, олон улсын гэрээ, конвенцийн шаардлага, ДЭМБ-ын зөвлөмж, бодлого, стратеги болон бусад улсын туршлага зэрэгт үндэслэн Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулах стратеги төлөвлөгөөг боловсруулсан болно.

Хоёр. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХХМ-ИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

- 2.1. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ нь эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад, нийт хүн амын эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх
- 2.2. ХХМ-ийг шийдвэрлэх стратеги, үйл ажиллагаа нь Монгол улсын Засгийн Газрын тэргүүлэх чиглэл болон Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө, бусад хөтөлбөр болон стратегийн үйл ажиллагаатай уялдсан байх
- 2.3. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ нь удаан задардаг органик бохирдуулагчийн талаарх Стокгольмын конвенц, Аюултай хог хаягдлыг хилээр дамжуулан тээвэрлэх үйл ажиллагааг зохицуулах тухай Базелийн конвенц зэрэг олон улсын конвенцийг дэмжих, ДЭМБ, бусад олон улсын түвшний байгууллагын стратеги, бодлогод нийцсэн байх
- 2.4. Уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол, тэдгээрээс үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэхийн тулд эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг шатаах бус аргаар устгах технологийг дэмжиж, хог хаягдлыг халдвартгуйжүүлэх, устгахад байгаль орчинд ээлтэй арга, технологийг нэвтрүүлэх
- 2.5. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулахад үндэсний болон орон нутгийн түвшинд чадавхи бүрдүүлэх
- 2.6. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын зүгээс эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг санхүүжүүлэх тогтвортой механизм бүрдүүлж, шаардагдах хөрөнгийг төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгах, хандивлагч байгууллага, хамтрагч талуудаас санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх
- 2.7. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлын хэмжээ, хортой байдлыг бууруулах шинэ санаа, санаачлагыг дэмжих
- 2.8. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-д төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих

Гурав. ЗОРИЛГО

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, боловсруулах, устгах оновчтой тогтолцоог бүрдүүлж, байгаль орчин, хүний эрүүл мэндийг хамгаалахад энэхүү стратеги төлөвлөгөөний зорилго оршино.

Дөрөв. ЗОРИЛТ

- 4.1. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн салбар хоорондын зохицуулах механизм бүрдүүлж, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- 4.2. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн хууль эрхзүйн зохистой орчин бүрдүүлэх
- 4.3. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн санхүүжилтийн тогтвортой механизмыг бүрдүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх
- 4.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалд хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах, боловсруулах асуудлыг цогцоор шийдвэрлэх дэд бүтцийг бүрдүүлэх
- 4.5. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн чиглэлээр хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, эмнэлгийн ажиллагсад, шийдвэр гаргагчид болон ард иргэдийн мэдлэг, хандлагыг сайжруулах
- 4.6. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээг сайжруулах

Тав. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 5.1. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулах зорилгоор байнгын ажиллагаатай салбар дундын зохицуулах механизмыг бий болгох
- 5.2. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн талаарх өнөөгийн журам, стандарт зэрэгт үнэлгээ хийж, ХХМ-ийг сайжруулах хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын үйл ажиллагааг стандартчилах
- 5.3. Эрүүл мэндийн салбарын бүх түвшинд (үндэсний, бүсийн, байгууллагын) ХХМ-ийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
- 5.4. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, халдвартгүйжүүлэх, устгахад шаардлагатай дэд бүтцийг бий болгох
 - 5.4.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, багасгах, дахин ашиглах байгаль орчинд ээлтэй шилдэг туршлагуудыг дэмжин дэлгэрүүлэх
 - 5.4.2. Хурц үзүүртэй хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх стандартын хайрцаг, сав, уут болон зориулалтын тэргэнцэр үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

- 5.4.3. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх, халдвартгуйжүүлэх, устгах үйлчилгээг бий болгож, тогтмолжуулах
- 5.4.4. Томоохон хот, аймгийн төвүүдэд шатаах бус (автоклав, богино долгионы зуух г.м) технологийг дэмжин, хог хаягдлыг халдвартгуйжүүлэх, устгах төвлөрсөн байгууламж барих арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх
- 5.4.5. Сумын эмнэлгийн хог хаягдлыг халдвартгуйжүүлэх автоклаваар хангах, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын булах цэг, байгууламжийг байгуулах
- 5.5. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг халдварт хамгаалал, өвчтөний аюулгүй байдал болон аюулгүй тарилгын үйл ажиллагаатай уялдуулах
- 5.6. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдалтай харьцдаг хүмүүсийг аюулгүй ажиллагааны хэрэгслээр бүрэн хангах, гепатит В, С вирусын эсрэг вакцинжуулалтад хамруулах
- 5.7. Мөнгөн ус агуулсан эмнэлгийн хэрэгслийн тооллого хийх, эрүүл мэндийн салбарт мөнгөн усны хэрэглээг багасгах болон зогсоох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх
- 5.8. Эрүүл мэндийн байгууллагын хий, шингэн хог хаягдлын менежментийг сайжруулах
- 5.9. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн бүртгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэсний тогтолцоо бий болгох
- 5.10. ХХМ-ийн үйл ажиллагааг эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлтэй холбох
- 5.11. ХХМ-ийн талаар дипломын өмнөх болон дараах сургалтыг бэхжүүлэх, зайн болон ажлын байран дээрх сургалтыг дэмжих замаар ХХМ-ийн хүний нөөцийг чадавхижуулах
- 5.12. Үндэсний хэмжээний эрүүл мэндийн стратеги, хөтөлбөрүүдэд хог хаягдлын менежментийн талаар тусгах
- 5.13. Шийдвэр гаргагчид болон нийт хүн амын ХХМ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх
- 5.14. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг цогцоор шийдвэрлэхэд хувийн сектор, ТББ болон хувь хүний оролцоог нэмэгдүүлэх

Зургаа. СТРАТЕГИЙН САНХҮҮЖИЛТ

Стратегийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- Төвлөрсөн ба орон нутгийн төсөв;
- Засгийн газрын нээлт хөрөнгө
- Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусlamж;
- Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусlamж;
- Бусад эх үүсвэр

Стратегийн санхүүжилтэд нийт 3,029 сая төгрөг шаардлагатай.

Долоо. ХЭРЭГЖИХ ХУГАЦАА БА ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1. Энэхүү стратеги төлөвлөгөө нь 2009-2013 онуудад хэрэгжинэ.

7.2. Үндэсний хэмжээнд стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, төлөвлөгөөг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулах ажлыг ЭМЯ-ны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэх бөгөөд шаардлагатай бол хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэж болно.

7.3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

Шалгуур үзүүлэлт	2008 оны суурь түвшин	2010 онд хүрэх түвшин	2013 онд хүрэх түвшин
ХХМ-ийн төлөвлөгөөтэй эрүүл мэндийн байгууллагын хувь	*	40	80
ХХМ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй эрүүл мэндийн байгууллагын хувь	*	70	100
Шаардлагад нийцсэн хог хаягдлыг түр хадгалах байртай эрүүл мэндийн байгууллагын хувь	*	30	80
Эмнэлгийн байгууллагын хог хаягдлыг устгах нэгдсэн байгууламжтай хот, аймгийн тоо/хувь	*	10	40
Эрүүл ахуйн шаардлага хангасан эмнэлгийн хог хаягдал устгах байгууламжтай сумын эмнэлгийн хувь	*	15	40
Эмнэлгийн тусгай хог хаягдлын эзлэх хувь -хотод -хөдөө орон нутагт	35-46 *	20 20	<15 <15
Эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд: - эрүүл мэндийн байгууллагын хог хаягдалд төсөвлөсөн санхүүжилтийн эзлэх хувь			

- эмнэлгийн төсөвт эрүүл мэндийн байгууллагын хог хаягдалд төсөвлөсөн санхүүжилтийн эзлэх хувь			
Эмнэлгийн хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын тээвэрлэлтийн үйлчилгээнд хамрагддаг эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	*	30	60

*-одоогийн байдлаар гаргах боломжгүй

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 9 дугаар сарын
...-ний өдрийн 23 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг (ХХМ) сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө
2009-2013

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хамтран ажиллах байгууллага	Шалгур үзүүлэлт	Санхүүжилт, сая төгрөг	Санхүүжилтийн эх үүсвэр
Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн сайжруулах зохицуулах механизм бүрдүүлж, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох						
1.	Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн сайжруулах дундын байгын ажиллагаатай зохицуулах механизм /ажлын хэсэг-ийг үндэсний болон орон нутгийн түвшинд бурдүүлэх, үйл ажиллагааг нь тоогтворжуулах	2009-2013	СЯ, БОДЖЯ, МХЕГ, аймаг / нийслэлийн ЗДТГ болон эрүүл мэндийн газар	Ажлын хэсэг байгуулсан тухай шийдвэр, ажлын хэсгийн уулзалтын тоо	20,0	Улсын төсөв Хандивлагч
2.	Эрүүл мэндийн сайжруулах түүчинд (ундэсний, бусийн, байгууллагын) эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх	2009-2013	Эрүүл мэндийн байгууллагууд	ХХМ-ийн төлөвлөгөөтэй эрүүл мэндийн байгууллагын хувь	10,0	Улсын, орон нутгийн төсөв
3.	Эрүүл мэндийн сайжруулахад ХХМ-ийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоотой болох	2009-2010	Эрүүл мэндийн газар, орон нутгийн засаг захиргаа	ХХМ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй эрүүл мэндийн байгууллагын хувь	-	

4.	ЭМБХМ-ийг эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй өвчтөний аюулгүй байдал, халдварын хяналт, аюулгүй тарилга зэрэг хөтөлбөр, төсөл, санаачлагатай уялдуулах арга хэмжээ авах	2009-2011	ЗГХА-ЭМГ, НЭМХ, олон улсын байгууллагууд, хандивлагчид	Уялдсан төсөл, хөтөлбөрийн хувь	30,0	Хандивлагч
Зорилт 2. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн хууль эрхзүйн зохицтой орчин бурдүүлэх						
5.	Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн талаар мөрдөгдөж буй хууль эрхийн акт, журам, зааврын хэрэжилтэд үнэлгээ хийж, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, ЭМХХМ-ийн тухай хууль боловсруулах	2009-2011	БОАЖЯ, ХЭДХЯ, МХЕГ, ЗГХА-ЭМГ, НЭМХ, эрүүл мэндийн байгууллагууд	Үнэлгээний тайллан, нэмэлт өөрчлөлт оруулсан / шинэчилсэн баримт бичиг, батлагдсан хууль	10,0	Улсын төсөв Хандивлагч
6.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шагалд хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устахаа удирдамж, стандарт, гарын авлагаа боловсруулах	2009-2011	БОАЖЯ, СХЗҮТ, МХЕГ, орон нутгийн засаг захиргаа	Баталсан удирдамж, стандарт	15,0	Улсын, орон нутгийн төсөв Хандивлагч
7.	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устахаа боловсруулах Үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажиллах журам (тавигдах шаардлага) боловсруулан батлуулах	2009-2010	БОАЖЯ, МХЕГ, ХӨСҮТ	Батлагдсан журам	2,0	Улсын төсөв Хандивлагч
8.	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх, устахаа үйл ажиллагааны төлбөрийн жишиг тогтоох	2009-2010	СЯ, орон нутгийн засаг захиргаа	Төлбөрийн жишиг тогтоосон шийдвэр	3,0	Улсын төсөв

9.	Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалтуурт ХХМ-ийн үзүүлэлтүүдийг тусгах, хэрэгжүүлэх	2009-2010	ЗГХА-ЭМГ	Магадлан итгэмжлэлийн шалтуурт орсон ХХМ-ийн үзүүлэлт	10,0	Улсын төсөв
Зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн санхүүжилтийн тогтвортой механизмыг бүрдүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх						
10.	Төвлөрсөн болон орон нутгийн жил бүрийн төсөвт эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулахад шаардагдах санхүүжилтийг тусгах, шийдвэрлүүлэх	2009-2013	СЯ, орон нутгийн засаг захирагаа	Төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс ХХМ-д хуваарилсан хөрөнгийн хэмжээ	-	-
11.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг хадгалах, цуглуулах, халдвартгийжүүлж, тээвэрлэх, устгах, боловсруулах тоног төхөөрөмжийн зардалд зориулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гаргах, эдийн засгийн тооцоо хийх	2009-2010	СЯ, БОАЖЯ	Хөрөнгө оруулалтын төлөвлөө, эдийн засгийн тооцоо	10,0	Улсын төсөв Хандивлагч
12.	Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулахад олон улсын байгууллага, хандивлагчдын дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэх, нөөцийг оновчтой ашиглах	2009-2013	Олон улсын байгууллага, хандивлагчид	Хэрэгжсэн төслийн тоо, дайчипсан хөрөнгийн хэмжээ	-	-
13.	Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд ЭХХ-ыг цуглуулах, устгах Үйл ажиллагаанд зарцуулж буй санхүүжилтийн байдалд үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авах	2009-1010	МХЕГ, НЭМХ, НЭМГ, олон улсын байгууллага, хандивлагчид	Үнэлгээний тайлан	10,0	Хандивлагч

Зорилт 4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шаталанд хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах, боловсруулах асуудлыг цогцоор шийдвэрлэх дэд бүтцийг бурдүүлэх

14.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг хадгалах, цуглуулах, халдвартгийг бий, тээвэрлэх, устгах, боловсруулахад шаардлагах материал, тоног төхөөрөмжийн жагсаалт гаргах, тэдгээрийн техник узүүлэлтийг нарийвчлан боловсруулах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд эзлэх техникик технологи нийтүүлэх механизмыг бурдүүлэх	2009-2010	БОАЖЯ, МХЕГ, НЭМХ, ХӨСҮТ, эрүүл мэндийн байгууллагууд	Шаардлагдах материал, тоног төхөөрөмжийн жагсаалт	3,0	Улсын төсөв
15.	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх стандартын шаардлага хангасан уут, сав, аюулгүй хайрцаг, тэргэнцэр үйлдвэрлэх, ханган нийтүүлэх байгууллагуудыг Мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллас	2009-2013	МХЕГ, хувийн хэвшил, олон улсын байгууллага, ТББ	Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн үйл ажиллагаанд оролцдог байгууллагын тоо	10,0	Улсын төсөв
16.	Эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл ахуйн шаардлагад нийцэн хог хаягдлай тур хадгалах байр/цэгийг бий болгож, байнгын ажиллагааг хангах	2009-2013	МХЕГ, аймаг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд	Шаардлагад нийцэн хот хаягдлай тур хадгалах байртай эрүүл мэндийн байгууллагын хувь	200,0	Улсын болон орон нутгийн төсөв
17.	Томоохон хот, аймгийн төвүүдэд эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах, устгах нэгдсэн байгууламжийн ерөнхий шаардлага, зураг төсөл, техник эдийн застийн үнэлгээг	2009-2011	БОАЖЯ, МХЕГ, ЭМГ, орон нутгийн засаг захиргаа, олон улсын байгууллага	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын нэгдсэн байгууламжид, тавих шаардлага	10,0	Улсын, орон нутгийн төсөв

	боловсруулах		боловсруулах	боловсруулах	боловсруулах	боловсруулах
18.	Дархан-Уул, Ховд аймгийн сонгосон эрүүл мэндийн байгууллагуудыг ХХМ-ийн чиглэлээр загвар аймаг болгох	2009-2010	Аймгийн ЭМГ, олон улсын байгууллагууд	Загвар байгууллагын тоо	200,0	Улсын төсөв Хандивлагч
19.	Улаанбаатар хотод эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг устах нэгдсэн байгууламж байгуулах	2009-2011	НЭДТГ, БОАЖЯ, МХЕГ, НЭМГ	Нэгдсэн байгууламжтай болно	200,0	Улсын төсөв Хандивлагч
20.	Томоохон хот, аймгийн төвүүдэд эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах, устах нэгдсэн байгууламж барих асуудлыг үе шаттай шийдвэрлэх	2009-2013	БОАЖЯ, орон нутгийн засаг захиргаа, олон улсын байгууллага	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг стандартын дагуу устгах байгууламжтай хот, аймгийн тоо	1,680	Улсын төсөв Хандивлагч
21.	Сумын эмнэлэгт булах цэг болон эрүүл мэндийн хог хаягдлыг устах байгууламж барихад тавих шаардлага, аргачлал боловсруулах, мөрдөх	2009-2013	БОАЖЯ, МХЕГ, ЗГХА-ЭМГ, орон нутгийн засаг захиргаа, эрүүл мэндийн байгууллагууд	Булах цэг/байгууламжид, тавих шаардлага, аргачлалыг баталсан шийдвэр	2,0	Улсын, орон нутгийн төсөв Хандивлагч
22.	Эмнэлгийн хог хаягдлыг халдвартайжүүлэх жижиг оврын автоклаваар сумын эмнэлгүүдийг хангаж, эрүүл ахуйн шаардлага хангасан булах цэг / байгууламж барих	2009-2013	БОАЖЯ, орон нутгийн засаг захиргаа, хандивлагч байгууллагууд	Эмнэлгийн хог хаягдлыг халдвартайжүүлэх автоклавтай сумын эмнэлгийн хувь	437,0	Улсын, орон нутгийн төсөв Хандивлагч

Зорилт 5. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн чиглэлээр хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, эмнэлгийн ажиллалгасад, шийдвэр гаргагчид болон ард иргэдийн мэдлэг, хандлагыг сайжруулах

				ЭМНЭЛГИЙН ХУВЬ		
23.	Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч наарт эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийг сайжруулах талаар ухуулга сурталчилгаа хийх	2009-2013	БОАЖЯ, хандивлагч байгууллагууд	Таниулан сурталчилсан үйл ажиллагааны тоо Оролцсон хүмүүсийн тоо	10,0	Улсын төсөв Хандивлагч
24.	Эрүүл мэндийн их дээд, дунд сургуулийн дипломын өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн сэдвийг оруулах, боловсронгуй болгох	2009-2010	БСШУЯ, анагаахын их сургууль, коллежүүд	Батлагдсан сургалтын хөтөлбөр	2,0	Улсын төсөв
25.	Эрүүл мэндийн болон бусад салбарын мэргэжилтнүүдэд ЭМБХХМ-ийн чиглэлээр давтан сургалтуудыг зохион байгуулах	2009-2013	ЗХА-ЭМГ, НЭМХ, ЭМШУИС	Сургалтын үйл ажиллагааны тоо Оролцсон хүмүүсийн тоо	30,0	Улсын төсөв Хандивлагч
26.	ЭМБХХ-ын талаар хүн амд чиглэсэн сургалт сурталчилгаа зохион байгуулах	2009-2013	ЗХА-ЭМГ, НЭМХ	Сургалт сурталчилгааны үйл ажиллагааны тоо	20,0	Улсын төсөв Хандивлагч
27.	Энэтхэг улсын Индра Гандигийн нэрэмжит Нээлттэй их сургуультай хамтран эруул мэндийн байгууллагын ХХМ-ийн чиглэлээр зайны сургалт зохион байгуулах	2009-2013	ДЭМБ, ХӨСҮТ	Зайны сургалтанд хамрагдсан байгууллагын тоо	10,0	Олон улсын байгууллаг а

28.	Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсын тархалтын түвшин болон хурц узүүртэй зүү тариут хатгалтын байдлыг үнэлэх судалгаа хийх	2009-2010	ХӨСҮТ, ЭМШУИС, НЭМХ, хандивлагч байгууллагууд	Судалгааны тайлан	15,0	Улсын төсөв Олон улсын байгууллага
29.	Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсыг гепатит В, С-ээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд байгууллагын зардлаар хамруулах, байнгын тандалт хийх	2010-2013	Эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн ажиллагсын дархлаажуулалтын хамраптын хувь	30,0	Улсын төсөв Хандивлагч
30.	Эрүүл мэндийн байгууллагад ашиглаж буй мөнгөн ус агуулсан баагаж, хэрэгслийн хэрэглээний суурь судалгаа хийж, зөвлөмж боловсруулах, эрүүл мэндийн салбарын мөнгөн ус агуулсан тоног төхөөрөмжийн хэрэглээг баагасах, арилгахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээ авах	2009-2013	БОАЖЯ, МХЕГ, ГЕГ, НЭМХ, Эрүүл мэндийн байгууллагууд	Судалгааны тайлан	10,0	Улсын төсөв Хандивлагч
31.	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдын бүтэц тогтоох судалгааг тогтолжуулж, тусгай, аюултай хог хаягдын эзлэх хувийг бууруулах	2009-2013	Эрүүл мэндийн байгууллагууд	Судалгааны тайлан	5,0	Улсын төсөв
Зорилт 6. Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээг сайжруулах						
32.	Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн өнөөгийн байдалд нарийвчилсан үнэлгээ хийх, холбогдох арга хэмжээ авах	2009-2010	МХЕГ, ХӨСҮТ	Үнэлгээний тайлан	5,0	Улсын төсөв

33.	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын нэгдсэн мэдээллийн сантай болох	2009-2013	МХЕГ, ХӨСҮТ, Харьяа байгууллагууд	Мэдээллийн сан	20,0	Улсын, орон нутгийн төсөв
34.	Эрүүл мэндийн байгууллагын ХХМ-ийн журам, заавар, хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг тогтолцожуулах	2009-2013	МХЕГ	Тайлан	5,0	Улсын төсөв
35.	Стратеги төлөвлөгөөний дунд шатны болон эцсийн үнэлгээ хийх	2011-2013	БОАЖЯ, МХЕГ	Үнэлгээний тайлан	5,0	Улсын төсөв Хандивлагч
	Нийт төсөв				3,029	